



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар

11/24

Тавин


Зардал гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аварга малчин П.Баттөгс хүндэтгэл үзүүлэхэд зориулан 100,000 (Нэг зуун мянган) төгрөг, Алтаны унаганы эзэн, Алтан ишигний эзэнд хүндэтгэл үзүүлэхэд зориулан 185,000 (Нэг зуун наян таван мянган) төгрөг, Хөдөлмөрийн баатруудын уулзалтанд оролцсон Б.Дашзэвгэд замын зардалд зориулан 100,000 (Нэг зуун мянган) төгрөг, тус сумын уугуул иргэн Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Хоролын Зандраабайдийгийн шинэ номны хэвлэлийн зардалд зориулан 1,000,000 (Нэг сая) төгрөг, Сүм багийн иргэн Б.Пүрэвдоржийн бие даасан уран баримал, уран зургийн үзэсгэлэнд зориулан 1,000,000 (Нэг сая) төгрөг, нийт 2,385,000 (Хоёр сая гурван зуун наян таван мянган) төгрөгний зардал гаргасугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Уранцэцэг), Нягтлан бодогч (Ө.Уранбилэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ

481220084